



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/179

Эрдэнэт

Г Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.1.5/в/, 29.1.6/л/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 45, 78 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт Коронавируст халдвар /Ковид-19/-ын халдвар гарч батлагдсан тохиолдлууд нэмэгдэж байгаатай холбогдуулан аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үйл ажиллагааг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийг дуустал сунгасугай.

2. Орхон аймагт ирэх, аймгаас гарах зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 04 дүгээр сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд түр хязгаарласугай.

3.Баян-Өндөр, Жаргалант сумдын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 04 дүгээр сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд оройн 18.00 цагаас өглөөний 10.00 цаг хүртэл хугацаанд хориглосугай.

4.Байгууллага салбарынхаа хэмжээнд ариутгал, халдваргүйтгэлийг зохион байгуулж, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа (спорт зааланд тоглох, сургалт, семинар, цугларалт, уншлага, хэлэлцүүлэг, РС тоглоом, фитнес, спиннинг, нийтийн бүжиг)-г 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 04 дүгээр сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулахгүй байхыг иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

5. Аймгийн Онцгой комиссын зөвшөөрөлтэйгөөр Орхон аймаг, Эрдэнэт хотод орж, гарч, дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналт, ажлын зохион байгуулалтыг сайжруулж, албан ёсны хяналтын постоор орж ирээгүй зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг журамлах, жолооч, зорчигчдод холбогдох хариуцлага тооцох, тусгаарлах ажлыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Тагнуулын газар (М.Очирбат), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Бат-Өлзий), Мал эмнэлгийн газар (П.Эрдэнэжаргал), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт даалгасугай.

6.Энэхүү захирамжийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ